

ТӨРИЙН ӨМЧИТ УУЛ УУРХАЙН КОМПАНИУДАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ УДИРДЛАГА ТУЛГАМДСАН АСУУДАЛ БОЛЖ БАЙНА

М.Эрдэнэбат*, Н.Тунгалаг**

Хураангуй: Бизнесийг үр ашигтайгаар хөтлөн явуулахад нэн түрүүнд шаардагддаг хөрөнгийн чухал хэсэг нь эргэлтийн хөрөнгө төдийгүй тэдгээрийн зүй зохистой удирдлага нь бизнесийн үр ашигт ихээхэн нөлөөтэй юм. Энэхүү ажилдаа Монгол улсын эдийн засагт голлох нөлөө үзүүлдэг уул, уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон хувийн өмчит компаниудын эргэлтийн хөрөнгө болон эргэлтийн хөрөнгийн удирдлагын өнөөгийн байдалд хийсэн харьцуулсан судалгааг нэгтгэж, эдгээр компаниудад эргэлтийн хөрөнгийн зохистой удирдлагыг нэвтрүүлэх нь тулгамдсан асуудал болоод байгааг илтгэж харуулахыг зорьсон юм. Судалгааны үр дүнд төрийн өмчит уул, уурхайн компаниудын нөөцийн ихээхэн хэсэг бараа материалын төрлөөр зогсонги байдалд орсныг илтгэн, материаллаг нөөцийн оновчтой удирдлагыг нэвтрүүлэх санал дэвшүүлсэн ба энэ нь эдгээр компаниудын санхүүгийн үр дүнд эерэгээр нөлөөлнө гэж үзсэн.

Түлхүүр үг: Эргэлтийн хөрөнгө, эргэлтийн хөрөнгийн удирдлага, уул уурхайн салбар, төрийн өмчит компани

Нэг. Эргэлтийн хөрөнгө, түүнийг удирдах нь

Нэг жилийн буюу богино хугацаанд бизнесийн үйл ажиллагаанд хэрэглэгддэг хөрөнгүүдийг эргэлтийн хөрөнгө гэдэг. Эргэлтийн хөрөнгө хэт их байх нь зардлыг өсгөдөг бол бага байх нь үйл ажиллагаа доголдох төлбөрийн чадвар буурах зэрэг сөрөг талтай. Иймд эргэлтийн хөрөнгийг оновчтой удирдаж, зохистой түвшинд барьснаар байгууллагын үр ашиг нэмэгддэг талаар судлаачид “эргэлтийн хөрөнгийн үр дүнгүй удирдлага нь бизнесийн нэгжийн ашигт байдалд сөргөөр нөлөөлдөг”³ гэх зэргээр зохиол, бүтээлдээ тэмдэглэсэн

* МУИС, Бизнесийн сургууль, (E-mail) erdenebat_25@yahoo.com

** МУИС, Бизнесийн сургууль, (E-mail) tungalag88@yahoo.com

3 Gebrehiwot, A., Wolday, A. (2006). Micro and small enterprises (MSEs) finance in Ethiopia: Empirical evidence. Eastern Africa Social Science Research Review, Michigan State University Press

байдаг.

“Эргэлтийн хөрөнгийн үр ашигтай удирдлага нь аж ахуйн нэгжийн стратегийн үндсэн хэсэг болж хувьцаа эзэмшигчдэд үнэ цэнийг бий болгодог”⁴ тул эргэлтийн хөрөнгийн үр ашигтай удирдлага нь бизнесийн богино хугацааны хөрвөх чадварыг хангахад тусалдаг байна. “Тиймээс компаниуд тэдний үнэ цэнийг өсгөх эргэлтийн хөрөнгийн оновчтой түвшинг хадгалахыг ямагт хичээн ажилладаг байна.”⁵

Дээрх судлаачдын эргэлтийн хөрөнгийн талаарх үзэл баримтлалыг нэгтгэн авч үзвэл “Эргэлтийн хөрөнгийн удирдлагын гол зорилго нь эргэлтийн хөрөнгийн бүрэлдэхүүн хэсгүүдийн зохистой хэмжээг тогтоож, түүнтэй холбогдон гарах зардлыг бууруулж, компанийн үр ашгийг нэмэгдүүлэх явдал юм” гэж үзэж болохоор байна.

Мөнгө, авлага, бараа материалын удирдлага нь өөр өөрсдийн чиг үүргийн дагуу эргэлтийн хөрөнгийн удирдлагад нөлөөлж байдаг⁶. Иймд эргэлтийн хөрөнгийн бүрэлдэхүүн тус бүрийг оновчтой удирдаж чадсан эсэхээс компанийн үр ашигтай байдал, төлбөрийн чадвар зэрэг үзүүлэлтүүд хамаарах юм.

Хоёр. Уул уурхайн салбар Монгол улсын эдийн засагт

Монгол улс өргөн уудам газар нутагтай, газрын хэвлийн баялаг ихтэй улс тул уул уурхайн үйлдвэрлэл хөгжөөд 100 гаруй жил болсон. 1990-ээд оноос хөрөнгө оруулалтын орчинг тааламжтай болгох ажлууд хийгдэж хууль эрх зүйн тогтвортой орчинг бүрдүүлэхээр ажиллаж байна.

2016 оны 12-р сарын байдлаар 1,558 ашиглалтын тусгай зөвшөөрлийн хүрээнд 1.4 сая га газар уул уурхайн салбарт ашиглагдаж байна.⁷ Уул уурхайн салбарын голлох бүтээгдэхүүнүүд нь жоншны баяжмал, зэсийн баяжмал, молибден, нүүрс, алт, катодын зэс, төмрийн хүдэр, цайрын баяжмал зэрэг юм.

Уул уурхайн салбар нь Монгол улсын эдийн засагт голлох байр суурийг эзэлдэг салбар юм.

4 Afza.T, Nazir.M.S (2008), “Working Capital Management Policies of Firms: Empirical Evidence from Pakistan”, *Pakistan Journal of Commerce and Social Sciences*, Vol. 1, No. 1

5 Deloof, M. (2003). Does working capital management affect profitability of Belgian firms? *Journal of Business Finance & Accounting*, 30(3/4)

6 Schilling, G. (1996). Working capital's role in maintaining corporate liquidity. *TMA Journal*.16(5)

7 http://mram.gov.mn/wp-content/uploads/2017/01/monthly_report_2016_12-12.pdf

Хүснэгт 2.1. Уул уурхайн салбарын
Монгол улсын эдийн засагт үзүүлж буй нөлөө

Үзүүлэлт	2015	2014	2013	2012	2011	2010
ДНБ-д эзлэх хувь	17.6	17.0	15.9	17.8	21.8	22.4
Байр	I	II	I	I	I	I
Аж үйлдвэрийн бүтээгдэхүүнд эзлэх хувь	67.2	58.9	58.7	58.8	64.8	62.1
Байр	I	I	I	I	I	I
Экспортод эзлэх хувь	78.8	83.0	81.9	89.2	89.2	81.0
Байр	I	I	I	I	I	I

Эх сурвалж: Үндэсний статистикийн газар, <https://www.1212.mn>

2015 оны байдлаар гэхэд уул уурхайн салбар Монгол улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 17.6 хувийг, экспортын 78.8 хувийг эзэлж, 2014 оныг эс тооцвол ДНБ, аж үйлдвэрийн бүтээгдэхүүн, экспортод эзлэх хувь хэмжээгээр бусад салбаруудтай харьцуулахад нэгдүгээр байрт байна. Өөрөөр хэлбэл уул уурхайн салбар нь Монгол улсын эдийн засагт нөлөө үзүүлдэг хамгийн том салбар болжээ.

Уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт 2010 оноос хойш эрчимтэй нэмэгдэж 2014 онд оргил үедээ 5,925.0 тэрбум төгрөгт хүрч байсан. Энэ хугацаанд гадаадын 22 улсаас хөрөнгө оруулалт хийж байжээ.

Гурав. Уул уурхайн компанийн санхүүгийн зарим үзүүлэлтүүд

Монгол улсад олборлолт, үйлдвэрлэл явуулж байгаа компаниудаас одоогоор үйлдвэрлэлийн үйл ажиллагаа нь жигдэрсэн, улсын төсвийн орлогыг голлон бүрдүүлдэг, салбартаа санхүүгийн үзүүлэлтээр томд тооцогддог зэрэг үндэслэлээр 15 компанийн санхүүгийн зарим мэдээлэлд шинжилгээ хийж үзэв. Эдгээрээс Эрдэнэт үйлдвэр, Эрдэнэс таван толгой ХК, Багануур ХК гэх мэт 6 компани нь төрийн өмчийн оролцоотой, Энержи ресурс ХХК, Болд төмөр ерөө гол ХХК, Монгол алт ХХК зэрэг 9 нь хувийн өмчит компани юм. Судалгаанд хамрагдсан компаниуд нь салбарын нийт актив болон орлогын дийлэнх хувийг эзэлж уг салбарыг тодорхой хэмжээнд төлөөлж байгаа болно. Санхүүгийн аливаа үзүүлэлтээр дүгнэлт өгөхдөө салбарын дундажтай харьцуулдаг. Иймд дэлхийн дөрвөн том нягтлан бодох бүртгэлийн компанийн нэг болох РwС (PricewaterhouseCoopers)-ээс жил тутам гаргадаг Дэлхийн уул уурхайн топ-40 компанийн санхүүгийн үзүүлэлттэй харьцуулж дүгнэлээ. Дэлхий уул уурхайн топ-40 компанид ВНР Billiton Limited, Rio Tinto Limited, China Shenhua Energy Company Limited, Coal India Limited зэрэг уул уурхайн

бизнес олон жил үйл ажиллагаа явуулсан компаниуд багтаж байгаа юм. Уул уурхайн компаниудын хөрөнгө, санхүүжилтийн бүтэц, өөрчлөлтийн талаарх судалгааг 2011-2016 оны санхүүгийн үзүүлэлтүүд дээр тулгуурлан хийсэн.

3.1. Уул уурхайн компанийн хөрөнгө, эх үүсвэрийн бүтэц

Хөрөнгийн оновчтой бүтцийн талаар тогтсон норматив байдаггүй боловч дэлхийн топ-40 компанийн хөрөнгийн бүтэцтэй Монгол улсын томоохон 15 компанийн үзүүлэлтийг харьцуулж үзвэл:

Хүснэгт 3.1. Уул уурхайн компаниудын нийт хөрөнгийн бүтэц, %

Ангилал	Үзүүлэлт	2016	2015	2014	2013	2012	2011
Монголын төрийн өмчит компаниуд	Эргэлтийн хөрөнгө	6.5	8.6	12.8	15.9	11.3	14.7
	Эргэлтийн бус хөрөнгө	93.5	91.4	87.2	84.1	88.7	85.3
Монголын хувийн өмчит компаниуд	Эргэлтийн хөрөнгө	26.6	23.1	26.7	37.5	37.4	51.2
	Эргэлтийн бус хөрөнгө	73.4	76.9	73.3	62.5	62.6	48.8
Дэлхийн ТОП-40 компани	Эргэлтийн хөрөнгө	-	23.0	23.5	23.9	24.9	25.9
	Эргэлтийн бус хөрөнгө	-	77.0	76.5	76.1	75.1	74.1

Эх сурвалж: <https://e-balance.mof.gov.mn/EBalance/home.jsf>,
<https://www.pwc.com/>

Хүснэгт 3.1.-ээс харахад Монголын уул уурхайн компаниудын нийт хөрөнгөнд эргэлтийн хөрөнгийн эзлэх хэмжээ буурсаар байна.

Дэлхийн топ-40 компанийн эргэлтийн хөрөнгийн нийт хөрөнгөнд эзлэх хэмжээ дунджаар 24 орчим хувь, эргэлтийн бус хөрөнгө 76 орчим хувь байна. Мөн энэ бүтэц харьцангуй тогтвортой байгаа юм.

Төрийн өмчит компаниудын эргэлтийн хөрөнгийн хувийн жин дэлхийн топ-40 компанитай харьцуулахад эрс бага байгаа бөгөөд жил тутам эргэлтийн хөрөнгийн нийт хөрөнгөнд эзлэх хувь хэмжээ буурч байна. Эндээс Монголын төрийн өмчит компаниуд эргэлтийн хөрөнгө багатай, үндсэн хөрөнгөнд илүү их хөрөнгө оруулалт хийсэн байгаа нь харагдаж байна.

Хувийн өмчит компаниудын хувьд 2011-2013 онд эргэлтийн хөрөнгийн хувийн жин их (37.4-51.62 хувь) байсан боловч 2014 оноос хойш дэлхийн топ-40 компанийн хөрөнгийн бүтэцтэй адил болж чадсан нь эргэлтийн болоод эргэлтийн бус хөрөнгийн зохист түвшинг хангах талаар ажиллаж байгааг харуулж байна.

Хүснэгт 3.2. Уул уурхайн компаниудын эх үүсвэрийн бүтэц, %

Ангилал	Үзүүлэлт	2016	2015	2014	2013	2012	2011
Монголын төрийн өмчит компаниуд	Эзний өмч	10.6	13.8	15.8	17.8	25.0	30.6
	Өр төлбөр	89.4	86.2	84.2	82.2	75.0	69.4
Монголын хувийн өмчит компаниуд	Эзний өмч	0.6	8.4	3.5	9.0	23.8	26.8
	Өр төлбөр	99.4	91.6	96.5	91.0	76.2	73.2
Дэлхийн ТОП-40 компани	Эзний өмч	-	45.7	48.5	50.3	54.8	57.7
	Өр төлбөр	-	54.3	51.5	49.7	45.2	42.3

Эх сурвалж: <https://e-balance.mof.gov.mn/EBalance/home.jsf>,
<https://www.pwc.com/>

Монголын төрийн өмчит компаниудын хувьд жил тутам эзний өмч нь буурсаар 2016 оны байдлаар эзний өмчийн нийт эх үүсвэрт эзлэх хэмжээ 10.6 хувь болсон нь санхүүгийн эх үүсвэрийн хувьд бие дааж үйл ажиллагаа явуулах боломжийг хааж байна. Дэлхийн топ-40 компанийн хувьд эзний өмчийн нийт эх үүсвэрт эзлэх хэмжээ дунджаар 49 хувь байгаатай харьцуулахад энэ нь хэт доогуур үзүүлэлт юм. Иймд төрийн өмчит компанийн удирдлагууд эзний өмчийг нэмэгдүүлэхийн тулд зардлыг бууруулах ашигт ажиллагааг нэмэгдүүлэх, өр төлбөрийг багасгах талаар ажиллах шаардлагатай болжээ.

Хувийн өмчит компаниудын хувьд эзний өмчийн нийт эх үүсвэрт эзлэх хэмжээ жил тутам ихээхэн буурсан 2016 оны байдлаар 0.6 хувь байгаа нь гадны санхүүгийн эх үүсвэрийн хувьд бүрэн хараат байдалд орсныг илтгэж байна. Хувийн өмчит компаниуд ашигт ажиллагааг нэмэгдүүлэх улмаар хөрөнгө оруулалт татах замаар санхүүгийн энэ хүндрэлээс гарах зайлшгүй нөхцөл үүссэн байна.

Өр төлбөрийн нийт эх үүсвэрт эзлэх хэмжээ сүүлийн 6 жилийн дунджаар төрийн өмчит компаниудад 81.1 хувь, хувийн өмчит компаниудад 88.0 хувь байгаа нь уул уурхайн салбар санхүүгийн хувьд бүрэн тогтворжиж чадаагүй байгааг илтгэж байна. Дэлхийн топ компаниудын хувьд өр төлбөрийн нийт эх үүсвэрт эзлэх хувь дунджаар 49,0%, сүүлийн жилүүдэд бага хэмжээгээр нэмэгдсэн нь харагдаж байна. Өр төлбөрийн хэмжээ их байх тусам санхүүгийн зардал ихсэж бизнесийн ашигт ажиллагааг бууруулдаг билээ.

3.2. Уул уурхайн компанийн эргэлтийн хөрөнгийн бүтэц ба төлбөрийн чадвар

Аль ч бизнест эргэлтийн хөрөнгөөр богино хугацаат өр төлбөрөө төлөх чадвар санхүүгийн нэг чухал үзүүлэлтэд тооцогддог.

Хүснэгт 3.3. Уул уурхайн компаниудын эргэлтийн хөрөнгийн бүтэц, %

Ангилал	Үзүүлэлт	2016	2015	2014	2013	2012	2011
Монголын төрийн өмчит компаниуд	Мөнгөн хөрөнгө	19.9	14.9	18.2	4.0	3.8	32.1
	Авлага	12.2	12.6	27.7	26.3	42.4	44.4
	Бараа материал	59.9	52.4	46.3	61.9	42.0	20.5
	Бусад эргэлтийн хөрөнгө	7.9	20.1	7.8	7.8	11.8	3.0
Монголын хувийн өмчит компаниуд	Мөнгөн хөрөнгө	3.0	0.9	2.3	4.1	5.9	8.1
	Авлага	22.5	21.5	27.8	24.8	37.4	57.8
	Бараа материал	11.8	14.9	13.8	16.3	18.1	18.3
	Бусад эргэлтийн хөрөнгө	62.7	62.8	56.1	54.7	38.7	15.8
Дэлхийн ТОП-40 компани	Мөнгөн хөрөнгө	-	34.0	33.0	27.0	33.5	39.3
	Авлага	-	27.0	28.7	23.7	28.4	25.8
	Бараа материал	-	25.3	26.9	25.7	25.2	25.1
	Бусад эргэлтийн хөрөнгө	-	13.7	11.5	23.7	12.9	9.8

Эх сурвалж: <https://e-balance.mof.gov.mn/EBalance/home.jsf>,
<https://www.pwc.com/>

Дэлхийн топ-40 компанийн эргэлтийн хөрөнгийн бүтэц харьцангуй тогтвортой байгаа нь эргэлтийн хөрөнгөө оновчтой удирдаж, энэ нь үйл ажиллагааны үр дүнд эерэгээр нөлөөлж байгааг харуулж байна.

Манай төрийн өмчит компаниудын эргэлтийн хөрөнгийн бүтцийг дэлхийн топ-40 компанигаар харьцуулахад мөнгөн хөрөнгө бага, энэ нь мөнгөн хөрөнгийн хомсдол үүсэх эрсдлийг дагуулж байгаа, авлагын хувийн жин харилцан адилгүй, топ-40 компанийн үзүүлэлтээс 2011, 2012 онд эрс их, 2013, 2014 онд ойролцоо, 2015, 2016 онд эрс бага байгаа юм. Гэхдээ төрийн өмчит компаниудын авлагыг бүтцээр нь авч үзвэл 40-60 хувь нь татварын авлага буюу татварын илүү төлөлт, үлдсэн нь борлуулалттай холбоотой авлага байсан. Харин дэлхийн топ-40 компанийн хувьд авлагын ихэнх хэмжээг борлуулалттай холбоотой авлага эзэлж байгаа юм. Энэ нь манай төрийн өмчит компаниудын

үйл ажиллагаанд төр татвараар дамжуулан ихээхэн оролцож байгааг харуулж байна.

Төрийн өмчит компаниудын бараа материалын эргэлтийн хөрөнгөнд эзлэх хэмжээ жил дараалан өссөн, дэлхийн топ-40 компанитай харьцуулахад 20-36 пунктээр илүү байгаа юм. Энэ нь төрийн өмчит компаниуд бараа материалын худалдан авалт, нөөцийн үлдэгдлийн хэмжээнд анхаарал тавьж ажиллаж чадахгүй байгааг харуулж байна. Иймд бараа материалын удирдлагыг оновчтой болгох үүднээс хэрэглээг зөв төлөвлөх, захиалгын процессийг сайжруулах, худалдан авалтад хяналт тавих хэрэгтэй.

Хувийн өмчит компаниудын эргэлтийн хөрөнгийн бүтцийг дэлхийн топ-40 компанитай харьцуулбал мөнгөн хөрөнгө эрс бага, авлага нь ойролцоо түвшинд, бараа материалын эргэлтийн хөрөнгөнд эзлэх хэмжээ 7-13 пунктээр бага байна.

Бусад эргэлтийн хөрөнгийн тухайд төрийн өмчит компаниудад урьдчилж төлсөн зардал буюу ирээдүйд зардалд шингэх хөрөнгүүд байна. Хувийн өмчит компаниудын хувьд бусад эргэлтийн хөрөнгийн 70-80 хувийг бэлтгэн нийлүүлэгчдэд урьдчилж төлсөн тооцоо буюу үндсэн хөрөнгө бэлтгэхтэй холбоотой хөрөнгө оруулалтууд тайлагнагдсан байна. Өөрөөр хэлбэл хувийн өмчит компаниудын бусад эргэлтийн хөрөнгө их байгаа шалтгаан нь үндсэн хөрөнгөнд хийх хөрөнгө оруулалтууд үргэлжилж байгааг харуулж байна. Энэ нь хувийн өмчит компаниуд үндсэн хөрөнгийн шинэчлэл, хөрөнгө оруулалтдаа ихээхэн анхаарал тавьж ажиллаж байгааг харуулна.

Эцэст нь дүгнэхэд дэлхийн топ компаниудтай харьцуулахад Монголын компаниуд мөнгөн хөрөнгө багатай, бараа материал болон бусад эргэлтийн хөрөнгө ихтэй, эргэлтийн хөрөнгийн бүтэц тогтворгүй байгаа нь эргэлтийн хөрөнгөө оновчтой удирдах зайлшгүй шаардлага үүссэнийг илтгэж байна.

Хүснэгт 3.4. Уул уурхайн компаниудын төлбөрийн чадварын зарим
үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Ангилал	2016	2015	2014	2013	2012	2011
Эргэлтийн харьцаа / удаа/	Монголын төрийн өмчит компаниуд	0.78	0.10	0.16	0.21	0.16	0.22
	Монголын хувийн өмчит компаниуд	0.46	0.46	0.47	0.82	0.85	0.93
	Дэлхийн ТОП- 40 компани	-	1.41	1.55	1.53	1.57	1.78
Түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа / удаа/	Монголын төрийн өмчит компаниуд	0.25	0.03	0.08	0.06	0.07	0.17
	Монголын хувийн өмчит компаниуд	0.12	0.10	0.14	0.24	0.37	0.62
	Дэлхийн ТОП- 40 компани	-	0.86	0.96	0.78	0.97	1.16

Эх сурвалж: <https://e-balance.mof.gov.mn/EBalance/home.jsf>,
<https://www.pwc.com/>

Дэлхийн топ-40 компанийн эргэлтийн харьцаа жил тутам буурсан үзүүлэлтэй боловч 1.41-ээс дээш үзүүлэлтэй байгаа нь богино хугацаат өр төлбөрийг төлөх чадвартайг харуулж байна. Мөн түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа багадаа 0.78-0.86 байгаа нь ойрын хугацаанд богино хугацаат өр төлбөрийн 78-86 хувийг буюу дийлэнхийг нь төлөх чадвартай, богино хугацааны төлбөрийн чадвар сайн байна. Харин Монголын компаниудын хувьд төлбөр түргэн гүйцэтгэх чадвар маш муу байна.

2011-2014 онуудад буюу уул уурхайн салбарын өсөлтийн үед ч эргэлтийн харьцаа эрс бага байгаа нь компаниуд эргэлтийн хөрөнгөө удирдах, богино хугацаат өр төлбөрийг багасгах тал дээр анхаарал тавин ажиллаж чадаагүйг харуулж байгаа юм. Дэлхийн топ-40 компанитай харьцуулахад эргэлтийн харьцаа хувийн өмчит компаниудад 2011-2013 онд 2 дахин, 2014-2015 онд 3 дахин бага, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар 2011-2013 онд 2-3 дахин бага байсан бол 2014-2015 онд 7-8 дахин бага болж буурчээ. Энэ нь бусад эргэлтийн хөрөнгийн өсөлт буюу төлбөр гүйцэтгэхэд нөлөөлөхгүй эргэлтийн хөрөнгийн хэмжээ ихэссэнтэй холбоотой.

Дэлхийн топ компаниуд төлбөрийн чадварын үзүүлэлтийг боломжит сайн түвшинд барьж үйл ажиллагаагаа явуулдаг байхад Монгол улсын компаниудын

хувьд төлбөрийн чадвар маш муу байгаа нь эргэлтийн хөрөнгийн удирдлага, санхүүжилтийн бодлогоо оновчтой хэрэгжүүлж чадахгүй байгааг харуулж байгаа юм.

3.3. Уул уурхайн компаниудын санхүүгийн зарим үзүүлэлтийн өөрчлөлтийн судалгаа

Уул уурхайн компаниудын хөрөнгө, эх үүсвэрийн үзүүлэлтүүд суурь он (2011 оныг 100 хувь гэж тооцсон)-оос хэрхэн өөрчлөгдсөнийг судаллаа.

Хүснэгт 3.5. Уул уурхайн компаниудын хөрөнгө, эх үүсвэрийн өөрчлөлтийн судалгаа

Ангилал	Үзүүлэлт	2016	2015	2014	2013	2012
Монголын төрийн өмчит компаниуд	Нийт хөрөнгө	253.5%	205.4%	205.3%	188.8%	143.4%
	Эргэлтийн хөрөнгө	112.9%	120.4%	178.6%	205.1%	110.6%
	Эргэлтийн бус хөрөнгө	277.7%	220.1%	209.9%	186.0%	149.0%
	Эзний өмч	87.4%	92.3%	105.7%	109.6%	117.3%
	Өр төлбөр	326.8%	255.4%	249.2%	223.8%	154.9%
Монголын хувийн өмчит компаниуд	Нийт хөрөнгө	197.1%	196.3%	168.8%	157.9%	129.6%
	Эргэлтийн хөрөнгө	102.2%	88.5%	88.1%	115.6%	94.6%
	Эргэлтийн бус хөрөнгө	296.7%	309.5%	253.4%	202.4%	166.3%
	Эзний өмч	4.6%	61.5%	21.8%	53.0%	115.4%
	Өр төлбөр	267.4%	245.6%	222.5%	196.3%	134.7%
Дэлхийн ТОП-40 компани	Нийт хөрөнгө	-	91.9%	104.0%	110.3%	109.3%
	Эргэлтийн хөрөнгө	-	81.7%	94.6%	101.7%	105.1%
	Эргэлтийн бус хөрөнгө	-	95.5%	107.3%	113.3%	110.8%
	Эзний өмч	-	72.8%	87.5%	96.2%	103.8%
	Өр төлбөр	-	118.0%	126.6%	129.5%	116.8%

Эх сурвалж: <https://e-balance.mof.gov.mn/EBalance/home.jsf>,
<https://www.pwc.com/>

Дэлхийн топ-40 компанийн хөрөнгө, эзний өмч буурсан, өр төлбөр өссөн үзүүлэлтэй байна. Энэхүү өөрчлөлт нь дэлхийн уул уурхайн бизнест гол нөлөө

үзүүлдэг ашигт малтмалын үнэ ханшийн бууралт, уул уурхайн бүтээгдэхүүний гол импортлогч орон БНХАУ-ын хэрэглээнээс ихээхэн хамаарч байгаа юм.

Монгол улсын төрийн өмчит компаниудын хувьд харин эсрэгээр нийт хөрөнгө 153.5 хувиар өссөн, энэ өсөлтөд эргэлтийн бус хөрөнгийн өсөлт ихээхэн нөлөө үзүүлжээ. Гэтэл энэ хугацаанд ашигт ажиллагаа буурснаар эзний өмч буурч, өр төлбөр 226.8 хувиар өссөн байна. Өрийн энэ өсөлт нь Дэлхийн топ-40 компанийн өсөлтөөс 2 дахин их байна. Хувийн өмчит компаниудын нийт хөрөнгө ба өр төлбөр нь 2015 оны хувьд дэлхийн топ-40 компанитай харьцуулахад тус тус 2.1 дахин өссөн байгаа юм. Энэ нь мөн л хөрөнгө оруулалтыг зээлээр санхүүжүүлж байсныг харуулж байна. Иймд зээлийг багасгах, компанид хөрөнгө оруулагчийг татах шаардлага үүссэн байна. Нөгөө талаар хувийн өмчит компаниудын эзний өмч 2011 оны эзний өмчийн дүнгээс 95.4 хувиар буурсан байгаа нь хэт их алдагдалтай ажилласныг илтгэж байна.

3.2 хэсэгт Монголын уул уурхайн компаниудын эргэлтийн хөрөнгийн гол анхаарал татах хэсэг нь авлага, бараа материал юм гэж дүгнэгдсэн тул эргэлтийн хөрөнгийн энэхүү хоёр үзүүлэлтийн өөрчлөлтийг судалж үзлээ.

Хүснэгт 3.6. Уул уурхайн компаниудын эргэлтийн хөрөнгийн өөрчлөлтийн судалгаа

Ангилал	Үзүүлэлт	2016	2015	2014	2013	2012
Монголын төрийн өмчит компаниуд	Авлага	31.1%	34.1%	111.5%	121.6%	105.7%
	Бараа материал	330.3%	307.7%	403.4%	619.9%	226.6%
Монголын хувийн өмчит компаниуд	Авлага	39.7%	32.9%	42.3%	49.6%	61.2%
	Бараа материал	66.1%	71.9%	66.7%	103.2%	93.5%
Дэлхийн ТОП-40 компани	Авлага	-	85.5%	105.3%	93.4%	115.8%
	Бараа материал	-	82.4%	101.4%	104.1%	105.4%

Эх сурвалж: <https://e-balance.mof.gov.mn/EBalance/home.jsf>.

<https://www.pwc.com/>

2016 онд Монголын төрийн өмчит компаниудын бараа материал нь 2011 оныхоос 230.3 хувиар буюу 2.3 дахин өссөн байна. Тэгвэл дэлхийн топ компаниуд зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулж бараа материалын

хэмжээгээ бууруулж байна. Эндээс манай төрийн өмчит компаниуд бараа материалын худалдан авалт, бараа материалтай холбогдон гарч байгаа зардлын үзүүлэлтүүдэд дүн шинжилгээ хийх хэрэгтэй болсон нь харагдаж байна.

Хүснэгт 3.7. Уул уурхайн компаниудын борлуулалт,
цэвэр ашигийн өөрчлөлтийн судалгаа

Ангилал	Үзүүлэлт	2016	2015	2014	2013	2012
Төрийн өмчит компаниуд	Борлуулалтын орлого	322.4%	338.7%	366.6%	113.6%	112.9%
	Цэвэр ашиг	-84.9%	-182.1%	-66.9%	-292.3%	-102.4%
Хувийн өмчит компаниуд	Борлуулалтын орлого	60.6%	41.9%	82.9%	85.9%	88.5%
	Цэвэр ашиг	-393.3%	-259.5%	-152.8%	-299.6%	20.9%
Дэлхийн ТОП-40 компани	Борлуулалтын орлого	-	75.9%	95.5%	102.5%	103.0%
	Цэвэр ашиг	-	-20.1%	37.3%	15.7%	50.7%

Эх сурвалж: <https://e-balance.mof.gov.mn/EBalance/home.jsf>,
<https://www.pwc.com/>

Уул уурхайн салбарт 2011 оноос хойш ашигт ажиллагаа эрс буурсан нь Хүснэгт 3.7.-оос харагдаж байна.

Харин манай компаниудын борлуулалтын орлого өссөн ч ашиг нь ихээхэн буурсан харагдаж байна. Борлуулалт нэмэгдсэн нь бүтээгдэхүүний үнийн бууралтын үед борлуулах тоо хэмжээгээ нэмэгдүүлсэн, 2014 оноос Оюутолгой ХК-ийн олборлолт борлуулалт эхэлсэнтэй шууд холбоотой ч зардлын өсөлт эрс их байсныг харуулж байна.

Судалгаа бүхэлдээ төрийн өмчит компаниудад эргэлтийн хөрөнгийн оновчтой удирдлага үгүйлэгдэж буйг харуулсан тул дараах дүгнэлт, саналуудыг дэвшүүлээ.

Дүгнэлт

Энэхүү судалгааны үр дүнд уул уурхайн салбарын хувьд бүтээгдэхүүний үнэ ханш буурсан, төгрөгийн ханшны уналт зэрэг олон хүчин зүйл энэ салбарын алдагдалд нөлөөлж байгаа хэдий ч эргэлтийн хөрөнгийн удирдлагыг оновчтой болгосноор алдагдлыг бууруулах боломжтой гэж үзлээ.

1. Төрийн өмчит компаниуд бараа материалын нөөцлөлт ихтэй байна. Бараа материалыг илүү нөөцөлсний үр дүнд өрийн санхүүжилт байх ёстой хэмжээнээс илүү хэмжээгээр ашиглагдаж, хүүгийн зардал, зээлийн шимтгэлийн зардал зэрэг зардлууд нэмэгдэж байна. Энэ санхүүжилтийн зардлаас гадна бараа материалыг их хэмжээгээр нөөцлөх, удаан хадгалалтын явцад гардаг зардлуудыг багасгахын тулд эргэлтийн хөрөнгийн оновчтой удирдлага шаардлагатай байна. Бараа материалтай холбоотой дараах зардлууд байгууллага дээр гардаг:

- Урт хугацаанд нөөцөлсөн бараа материал хэрэглэгдэхгүй болох: Техник, технологийн шинэчлэлтэй холбоотойгоор бараа материалууд нь хэрэглэгдэхгүй болдог. Үүнтэй холбоотойгоор ашиглагдахгүй, хэрэгцээгүй бараа материал үүсэж зардал, алданги нэмэгддэг.
- Бараа материалын чанар алдагдах: Хадгалалтын нөхцөл, шаардлагыг хангахгүй байхаас, удаан хугацаанд хадгалснаас гэх мэт шалтгаанаар бараа материал нь үйлдвэрлэл, үйл ажиллагаанд ашиглах боломжгүй болж үргүй зардал бий болдог.
- Бараа материалын хэмжээ ихэссэнээс агуулахын зардал өсөх: Бараа материалын хэмжээ нэмэгдэхийн хэрээр агуулах нэмж түрээслэх, барьж байгуулах, агуулахын ажилтан нэмэх, ашиглалттай холбоотой зардал нэмж гарах зэрэг олон төрлийн зардлууд дагалдан нэмэгддэг.
- Бараа материалын үнэ цэнэ зах зээл дээр буурах: Зах зээл дээр бараа материалын үнэ байнга өөрчлөгддөг бөгөөд зах зээлийн өрсөлдөөн, технологийн дэвшлээс хамаарч бараа материалын үнэ зах зээл дээр буурч болно. Иймд зах зээл дээр үнийн өөрчлөлт ихтэй байж болох барааг ихээр нөөцлөхгүй байх ёстой. Мөн худалдан авалтын ажилтнууд бараа материалын үнийн өөрчлөлтийг судалж, таамаглаж байх шаардлагатай юм.

Эдгээр зардлыг оновчтой бага түвшинд аваачих нь эргэлтийн хөрөнгийн удирдлагын нэг хэсэг юм.

2. Бараа материал нөөцийн үлдэгдлийг оновчтой түвшинд барих шаардлагатай байна. Бараа материалын нөөцийн үлдэгдлийн оновчтой хэмжээг тогтооходоо дараах аргуудыг ашиглах боломжтой.

- Бараа материалыг хэрэглээгээр ангилж үлдэгдлийн хэмжээ тогтоох (XYZ шинжилгээ): Бараа материалыг хэрэглээний түвшингээр нь хэрэглээ ихтэй (X), дундаж хэрэглээтэй (Y), бага хэрэглээтэй (Z) гэж ангилж худалдан авалтын бодлого, нөөцийн төлөвлөлтөө хийх

шаардлагатай.

- Бараа материалыг үнийн дүнгээр ангилж зарцуулалт, худалдан авалтад хяналт тавих (ABC шинжилгээ): Бараа материалыг үнийн дүнгээр нь үнэ ихтэй (A), дундаж үнэтэй (B), бага үнэтэй (C) гэж ангилж зарцуулалтад хяналт тавих шаардлагатай. Мөн худалдан авалт хийхдээ ч дээрх ангиллын дагуу худалдан авалтын үйл ажиллагааг удирдах хэрэгтэй. ABC, XYZ шинжилгээнүүдээр матриц үүсгэж бараа материалаа 9 ангилах замаар бараа материалын удирдлагыг хэрэгжүүлэх нь энэ хоёр аргыг тусад нь ашигласнаас илүү үр дүнтэй юм.
- Байнга хэрэглэгддэг буюу эргэлт ихтэй бараа материалын үлдэгдлийг дундаж эргэцэд үндэслэж тогтоох: Бараа материалын эргэцийн шинжилгээнд үндэслэж байнга хэрэглэгддэг бараа материалыг ямар хэмжээгээр худалдан авах, нөөцлөхөө тогтоох боломжтой.
- Тоног төхөөрөмжийн өртгийн хэдэн хувьтай тэнцэх сэлбэг хэрэгслийн зардлыг компанийн хувьд хүлээн зөвшөөрөх хэрэгтэйг тодорхойлох: ОХУ, Украин зэрэг улсад үйлдвэрлэлийн компаниуд сэлбэг хэрэгслийг тоног төхөөрөмжийн өртгийн тодорхой хувьтай тэнцүү байхаар зардлыг нормчилдог. Энэ нь сэлбэгийн зардлыг хянахад ихээхэн ач холбогдолтой байдаг байна.
- Бараа материалын худалдан авалтын оновчтой хэмжээг тогтоох: Бараа материалын жилийн хэрэгцээ, бараа материалтай холбогдон гарах зардлуудыг урьдчилан таамагласны үндсэн дээр Форд Хариссын боловсруулсан EOQ (economic order quantity—захиалгын оновчтой хэмжээ) загвар, энэ загварын өргөтгөсөн хувилбаруудыг ашиглах боломжтой. Ингэснээр бараа материалтай холбогдон гарах зардлыг боломжит бага түвшинд байлгаж чадна.

3. Төрийн өмчит компаниуд мөнгөний болон авлагын удирдлагад ч анхаарал хандуулах шаардлагатай байна.

Ашигласан материал

1. Afza.T, Nazir.M.S. (2008), “Working Capital Management Policies of Firms: Empirical Evidence from Pakistan”, Pakistan Journal of Commerce and Social Sciences, Vol. 1, No. 1
2. Charles T. Horngren, Srikant M. Datar, Madhav V. Rajan. 2015, Cost Accounting 15th edition, 2015
3. Deloof, M. (2003), Does working capital management affect profitability of Belgian firms? Journal of Business Finance & Accounting, 30(3/4)

4. Donald Waters. 2003, Inventory Control and Management
5. Gebrehiwot, A., Wolday, A. (2006). Micro and small enterprises (MSEs) finance in Ethiopia: Empirical evidence. Eastern Africa Social Science Research Review, Michigan State University Press
6. Jigjid Rentsendoo, (2014), Mongolian mining sector and investment, Ministry of mining
7. Schilling, G. (1996). Working capital's role in maintaining corporate liquidity. *TMA Journal*,16(5)
8. Г.Тамир. (2016), Монгол улсын уул уурхайн салбарын өнөөгийн байдал, эрх зүйн орчны шинэчлэлт, цаашид авах арга хэмжээ, Монгол улсын уул уурхайн яам
9. Монгол улсын сангийн яам, Э-баланс
<https://e-balance.mof.gov.mn/EBalance/pages/userAdmin/report.jsf>
10. Ашигт малтмал газрын тосны газар. (2016), Уул уурхайн салбарын статистик
http://mram.gov.mn/wp-content/uploads/2017/01/monthly_report_2016_12-12.pdf
11. PricewaterhouseCoopers. (2016), Mine-2016, Slower, lower, weaker... but not defeated
<https://www.pwc.com/gx/en/mining/pdf/mine-2016.pdf>
12. PricewaterhouseCoopers. (2015), Mine-2015, The gloves are off
https://www.pwc.com/cl/es/publicaciones/assets/mine-report_06-2015.pdf
13. PricewaterhouseCoopers. (2013), Mine-2013, Mine a confidence crisis
<https://www.pwc.com/gx/en/mining/publications/assets/pwc-mine-a-confidence-crisis.pdf>